



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 06 сарын 23 өдөр

Дугаар 8/91

Хэрлэн сум

Ажлаас чөлөөлж, түр орлон
гүйцэтгэгч томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.8, Хөдөлмөрийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.1.1, 39 дүгээр зүйлийн 39.2, 26 дугаар зүйлийн 26.1. "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн дүрмийн 3 дугаар зүйлийн 3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өмнөдэлгэр сумын "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн дарга Ц.Оюун-Эрдэнэ нь ажлаас чөлөөлөгдөх хүсэлтээ гаргасан тул 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс үүрэгт ажлаас чөлөөлж, хөдөлмөрийн гэрээг цуцалсугай.

2. Ц.Оюун-Эрдэнэд холбогдох тооцоог хийж дуусгахыг Өмнөдэлгэр сумын "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн нягтлан бодогч /Л.Сарантуяа/-д зөвшөөрсүгэй.

3. "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн даргыг томилогдох хүртэлх хугацаагаар "Хэнтий шинэс" сум дундын ойн ангийн инженер Л.Хандсүрэнг 2017 оны 06 дугаар сарын 23-ны өдрөөс албан үүргийг түр орлон гүйцэтгэгчээр томилсугай.

4. Ажил хүлээлцүүлэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Б.Дархантөр

-Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын дарга

Гишүүд:

Б.Мөнхжаргал

-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого
төлөвлөлтийн хэлтсийн үйлдвэр,
хөдөө аж ахуй, байгаль орчны бодлого
хариуцсан мэргэжилтэн

Л.Сарантуяа

-"Хэнтий шинэс" сум дундын ойн
ангийн нягтлан бодогч

Э.Батсайхан

-Байгаль орчин, аялал жуулчлалын
газрын ой ангийн мэргэжилтэн

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Ж.Ганбаатар/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА